



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: secretariat@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.07.09 № ТГ-02/844
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийн талаар” тавьсан 42 дугаар асуулгатай танилцлаа.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд асуулгад дурдсан асуудлаар Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дараах хариуг хүргүүлж байна.

1.Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос 2026 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд “Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал” сэдвээр зохион байгуулсан ерөнхий хяналтын сонсголын үеэр Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Ж.Золжаргал нар Туулын хурдны замын төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний урьдчилгаа төлбөртэй холбоотой асуудлаар асуулт тавьсан.

Дээрх асуултад Нийслэлийн Замын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Одбаярын өгсөн тайлбар нь сонсголд танилцуулсан шинжээчийн дүгнэлттэй зөрүүтэй байсан нь олон нийтэд буруу ойлголт төрүүлэх, бодит нөхцөл байдлын талаар зөрүүтэй мэдээлэл өгсөн байж болзошгүй гэж үзэх үндэслэл болсон.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.24, 21.26 дахь хэсгийг үндэслэн сонсгол даргалсан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалаас Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад хандан 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-03/7393 дугаартай “Тайлбар гаргуулах тухай”, Монгол Улсын Ерөнхий аудиторт хандан мөн өдрийн УИХ-03/7394 дугаартай “Дүгнэлт гаргуулах тухай” албан бичгийг тус тус хүргүүлсэн.

Үүний дагуу Улсын Их Хурлын Тамгын газар Нийслэлийн Замын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Одбаяраас Туулын хурдны замын төслийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах, худалдан авах ажиллагаа, барилга угсралтын ажлыг хэрэгжүүлэх гэрээний төлбөр тооцоо болон урьдчилгаа төлбөрийн нөхцөлтэй холбоотой тайлбарыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн ТГ-02/765 дугаартай албан бичгээр гаргуулан авсан.

2026001542

Мөн Үндэсний аудитын газраас “Туулын хурдны зам мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдал” аудитын тайланд үндэслэн холбогдох мэдээллийг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 1617 дугаартай албан бичгээр ирүүлснийг нэгтгэн холбогдох Улсын Их Хурлын гишүүнд хүргүүлсэн.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.16 дахь хэсэгт заасны дагуу 2026 оны 04 дүгээр сарын 03-наас 06 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд болсон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн асуудлуудтай холбогдуулан Улсын Их Хурлын даргаас нийт 50 асуудлаар Засгийн газар, холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнаас бичгээр мэдээлэл, тайлбар ирүүлэх чиглэл өгсөн.

Хэрэгжилтийн байдлыг нэгтгэн дүгнэвэл хэлэлцсэн асуудалтай холбоотойгоор хариултыг хангалтгүй гэж үзсэн 36 асуудлаар нэмэлт мэдээллийг холбогдох Улсын Их Хурлын гишүүдэд бичгээр хүргүүлэх, 1 асуудлаар Улсын Их Хурлын гишүүнд, 2 асуудлаар ажлын хэсэгт, 11 асуудлаар Улсын Их Хурлын Тамгын газарт тус тус үүрэг, чиглэл өгсөн бөгөөд эдгээрийн хэрэгжилт бүрэн хангагдаж, 100 хувь биелсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.

Холбогдох лавлагаа, мэдээллийг хавсаргав.

Хавсралт 16 хуудастай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА



Ж.БЯМБАДУЛАМ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 28 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: secretariat@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ж.ЗОЛЖАРГАЛ ТАНАА**

2026.06.30 № ТГ-02/465
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос 2026 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулсан "Нийслэлийн 2024-2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал" сэдэвт ерөнхий хяналтын сонсголын явцад Туулын хурдны замын төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний төлбөрийн талаар Нийслэлийн замын газрын дарга Б.Одбаярын өгсөн хариулттай холбогдуулан тайлбар гаргуулах тухай Таны 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-03/7393 дугаартай "Тайлбар гаргуулах тухай" албан бичигтэй танилцлаа.

Улсын Их Хурлын Тамгын газраас 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн замын газрын дарга Б.Одбаяраас Нийслэлээс хэрэгжүүлж буй "Туулын хурдны зам"-ын төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан барилгын ажлын зураг төсөл боловсруулах, худалдан авах, барилгын ажил гүйцэтгэх гэрээний төлбөр тооцоо, урьдчилгаа төлбөрийн нөхцөлийн талаарх тайлбарыг бичгээр гаргуулан авсанг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА



Ж.БЯМБАДУЛАМ

2026001366

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

"ТУУЛЫН ХУРДНЫ ЗАМ" ТӨСЛИЙН УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР

2026 оны 06 сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 02, 03 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн 2024 – 2026 оны төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилт холбогдох хууль тогтоомжид нийцсэн байдал" сэдвээр зохион байгуулж буй Ерөнхий хяналтын сонсголын үеэр УИХ гишүүн Б.Золжаргалын тодруулсан төслийн урьдчилгаа төлбөрийн талаарх тайлбар.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь "Туулын хурдны зам" төслийн гүйцэтгэгчтэй ийслэл Улаанбаатар хотод "Туулын хурдны зам" барих барилгын ажлын зураг төсөл боловсруулах, худалдан авах, барилгын ажил гүйцэтгэх НХААГ/20250101139 дугаартай гэрээ байгуулсан.
- Тус гэрээний хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 болон Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/252 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 3.2 дугаарт заасны дагуу гүйцэтгэгчийн ажлын бэлтгэл хангахад зориулан Гэрээний мэдээлэл хэсгийн 14.2-т заасны дагуу гэрээний үнийн дүнгийн 21.32% буюу 500 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид хэсэгчлэн олгосон. Мөн тус ГЕН 14.2-т "Захиалагч нь ажлыг эхлүүлэх болон зураг төсөлд зориулан урьдчилгаа төлбөрийг хүүгүй эзэл хэлбэрээр олгоно" гэж заасан.
- Хэрэв төсөл хэвийн үргэлжилсэн тохиолдолд ГЕН 14.6-т заасан "Явц дундын төлбөр"-ийн хүсэлт тус бүрээс ГЕН 14.2.3-т заасны дагуу суутгах замаар урьдчилгаа төлбөрийг буцаан төлүүлэхээр зохицуулсан.
- Хэрэв ажил дуусахаас өмнө гэрээний 15 дугаар зүйлийн дагуу захиалагч гэрээг цуцлах, 16 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэгч ажлыг түр зогсоох, гэрээ цуцлах болон 18 дугаар зүйлийн дагуу гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл үүссэн нөхцөлд Гүйцэтгэгч нь гэрээ цуцлахаас өмнө урьдчилгаа төлбөрөөс буцаан төлөгдөөгүй хэсгийг Захиалагчид бүрэн төлөхөөр зохицуулсан байдаг.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОДБАЯР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
ЖАРГАЛСАЙХАНЫ ЗОЛЖАРГАЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (978-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.07.01 № 1617

танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Таны 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-03/7394 дугаартай албан бичигтэй танилцлаа.


Үндэсний аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны "Аудитын сэдэв батлах тухай" 25 дугаар тогтоолын дагуу "Туулын хурдны зам" мега төслийг үр нөлөөтэй төлөвлөсөн байдал"-д аудит хийж, аудитын тайланг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

"Туулын хурдны зам"-ын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх НХААГ/20250101139 дугаартай гэрээний тусгай нөхцөлийн 14.2.3 (b)-д "Урьдчилгаа төлбөр эргэн төлөгдөж дуустал гэрээний дагуу хийгдэх төлбөр бүрийн 21.32 хувиар тооцож, суутгана. Ингэхдээ ГЕН-ийн 14.2.3 (a) дэд заалтыг баримталж, гэрээний нийт үнийн дүнгийн 10 хүртэл хувийн гүйцэтгэлээс урьдчилан төлбөрийг суутгахгүй", Жич: "Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын 4.8.14-т заасан санхүүжилтийн ерөнхий зохицуулалтын заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 78 дугаар тогтоолд заасан Олон Улсын зөвлөх инженерүүдийн холбооны гэрээний жишиг нөхцөлийг хэрэглэх хүрээнд зохицуулалтын харилцан зөрүү үүсэх тохиолдолд, уг жишиг гэрээний нөхцөлийг баримтлах буюу урьдчилгаа төлбөрийн буцаан төлөлтийг явц дундын гүйцэтгэл тус бүрээс суутгах, тухайн хугацаанд урьдчилгаа төлбөрийн баталгаа хүчинтэй хэвээр үйлчлэх нөхцөлийг хэрэгжүүлнэ." гэж заасан байна.

Төсөл хэвийн үргэлжилбэл гэрээний дээрх заалтын дагуу ажил гүйцэтгэх хуваарийн дагуу захиалагчаас гүйцэтгэлийн баримтыг хянан баталгаажуулж, санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох, төлбөр бүрийн дүнгээс 21.32 хувиар тооцож суутгахаар зохицуулсан байна. Өнөөгийн байдлаар гүйцэтгэл гараагүй бөгөөд урьдчилгаа төлбөрт олгосон 500.0 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаар аудитын тайланд дараах байдлаар тусгасан. Үүнд:

- Төслийн гүйцэтгэгч "Хаоюань Женерал Констракшн" ХХК нь Нийслэлийн Замын хөгжлийн газарт 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн НҮМ/2026-25 дугаар албан бичгээр урьдчилгаа төлбөрт олгосон 500.0 тэрбум төгрөгийн зарцуулалтыг 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 350.9 тэрбум төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 149.1 тэрбум төгрөг байгаа талаарх мэдээллийг ирүүлсэн байна;

- "Хаоюань Женерал Констракшн" ХХК нь Транс банканд төгрөгийн 9, юанийн 1, ам.долларын 1, Голомт банканд төгрөгийн 2, нийт 13 харилцах данс эзэмшиж байна. Аудитын гүйцэтгэлийн үе шатанд урьдчилгаа төлбөрийн зарцуулалт, үлдэгдлийн талаар тодруулахад дээр дурдсан дансдуудад 326.0 тэрбум төгрөг, 58.2 мянган ам.доллар, 38.4 сая юанийн үлдэгдэлтэй мэдээллийг ирүүлсэн;
- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн УЕПГ-ын 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн шийдвэрээр байгуулагдсан АТГ, ТЕГ, ЦЕГ-ын хамтарсан ажлын хэсгээс төслийн худалдан авах ажиллагаа, гэрээ хэлцэл, урьдчилгаа төлбөрийн баталгаа, санхүүжилтэд шалгалтын ажиллагааг хийж байгаатай холбоотойгоор аудитын хангалттай бөгөөд зохистой нотлох зүйл цуглуулах боломж хязгаарлагдаж, аудитын иж бүрэн дүгнэлт өгөх боломжгүй болсон тул Төрийн аудитын MNS 6817-5:2020 стандартын 4.2.6, 7.5.1-д заасны дагуу тухайн асуудлыг хязгаарлан аудитын тайланд тусгасан.



С.МАГНАЙСҮРЭН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.БЯМБАЦОГТООС
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ЯВЦАД ӨГСӨН
ҮҮРЭГ, ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ЛАВЛАГАА**

2026.07.08

Монгол Улсын Их Хурлын дарга С.Бямбацогтоос Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн **21 дүгээр зүйлийн 21.24 дэх хэсэгт** заасны дагуу 2026 оны 04 дүгээр сарын 03-наас 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хооронд болсон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаануудаар хэлэлцсэн асуудлуудтай холбогдуулан өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулж байна.

Нийт **30 удаагийн** чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан хариулт хангалтгүй гэж үзсэн **36 асуудлын** нэмэлт мэдээллийг тухайн гишүүнд бичгээр хүргүүлэхийг, **1 асуудлыг** Улсын Их Хурлын гишүүнд, **2 асуудлыг** ажлын хэсэгт, **11 асуудлыг** Улсын Их Хурлын Тамгын газарт тус тус үүрэг болгосон байна. Үүрэг даалгаврын биелэлт **100%**

ДЭЛГЭРЭНГҮЙ

Улсын Их Хурлын даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу дараах асуудал тус бүрд бичгээр хариултуудыг ирүүлсэн болон Улсын Их Хурлын гишүүдтэй биечлэн уулзаж хариу өгсөн талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулж байна.

№1	2026.04.10 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
----	--

УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны асуултад өгсөн хариулт хангалтгүй гэж үзэж, хууль зүйн үндэслэл, тайлбар болон холбогдох мэдээллийг гүйцээн бичгээр хүргүүлэх

ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга **Б.Бат-Эрдэнэ**;

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Э.Билэгт** нар 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 1/318 дугаар албан бичгээр; Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1379 дугаар албан бичгээр тус тус хариу ирүүлсэн байна.

№2	2026.04.16 "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2026.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/
----	---

№5

2026.04.24

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн/

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингийн тавьсан тендерт шалгарсан компаниудын эзэмшил, хамаарал болон төслийн өртөгтэй холбоотой асуултад нэмэлт тодруулга хүргүүлэх

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/2688 дугаар албан бичгээр хариу ирүүлсэн байна.

№6

2026.04.24

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.12-ны өдөр өргөн мэдүүлсэн/

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын тавьсан асуулт, саналтай холбоотой нэмэлт тайлбар, мэдээллийг бичгээр хүргүүлэх.

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

Үүний дагуу Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/4290 дугаар албан бичгээр хариуг ирүүлсэн байна.

№7

2026.04.30

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар 2025.05.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшингээс дагалдан боловсруулсан журмын төслийг авах хүсэлт гаргасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаярт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, тайлагнах журам болон аргачлалын төслийг бичгээр хүргүүлэх

№10	2026.05.01 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хүүнийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П Сайнзориг нарын 8 гишүүн 2026.04.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх
-----	--

УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан саналын дагуу давхардсан агуулгатай хуулийн төслүүдийг тусад нь хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Улсын Их Хурлын Тамгын газарт үүрэг болгосон.

ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болгох тухай хуулийн төслийг өргөн барьсан нь давхардал үүсгэж байгаа тул ажлын хэсгийг салгаж явуулахаар болсон.

№11	 2026.05.07 "Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/
	 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ С.Бямбацогт: Хуулийн төслийн нэршил албан бичиглэлд өөр өөрөөр яваад байгаа тул ажлын хэсэг нэршлийг нэг тогтсон нэршилээр явах, засах.
	 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН • Ажлын хэсэг Хууль батлагдсаны дараа нэр өөрчлөгдөнө.
№12	 2026.05.07 Цусны донорын тухай хуулийн төслийн танилцуулга /Анхны хэлэлцүүлэг/
	 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ С.Бямбацогт: Улсын Их Хурлын чуулганы танхим дахь индэр лүү хүрэх хэсгийн замыг өргөн болгож, хүн явахад саадгүй болгох.
	 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН • Улсын Их Хурлын Тамгын газар

III ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

- Улсын Их Хурлын Тамгын газар нь өгсөн үүрэг даалгаврыг бүртгэн, холбогдох байгууллагаас хариу албан бичгийг тодруулан албажуулж, биелэлтийн мэдээ бэлтгэн ажиллаж байна.

№14 2026.05.14

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

III ҮИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

М.Ганхүлэг: Гамшгийн эрсдэлийг хэрхэн тооцоолсон талаар, яг тооцоолох аргачлалын дагуу тооцоолсон эсэх асуудлаар хариулт дутуу хариулаад байна.

III ҮИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: Гишүүний асуусан гамшгийн эрсдэлтэй холбоотой асуултад хугацаандаа багтаж хариулт өгч чадахгүй байгаа тул бичгээр хариуг хүргүүлнэ.

III ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

- Ажлын хэсэг мэдээллийг М.Ганхүлэг гишүүнд хүргүүлсэн байна.

№15 2026.05.14

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

III ҮИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Н.Алтаншагай: Цалинтай ээж хөтөлбөрт нэмэлтээр залуу гэр бүлд бодит дэмжлэг болохуйц тусламжийн бодлогын томоохон шийдэл оруулж ирэхийг хүсэж байна.

III ҮИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

- Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай гишүүний тавьж буй саналд бичгээр хариу хүргүүлнэ.

III ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

- Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2026.05.29-ний өдөр батлагдсан болно.

№16 2026.05.14

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

УИХТГ нь хүнд суртал үүсэхээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг шуурхай, үр нөлөөтэй хүргэх асуудлыг онцгой анхааран ажиллаж байна.

№17  2026.05.14
"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

 УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Дав.Цогтбаатар: Төрийн албан хаагчдын орон тоог буулгаад байгаа боловч нөгөө талдаа Барилгын хөгжлийн төв болон бусад төрийн өмчит байгууллагууд нь орон тоогоо нэмээд байгаа талаар.

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: УИХ-ын гишүүн Дав.Цогтбаатарын асуусан Барилгын хөгжлийн төвийн орон тоог яагаад нэмсэн эсэх асуултад бичгээр хүргүүлэх.

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН -3

• ТӨБЗГ-ын 2026.05.18-ны өдрийн А-01/979 дүгээр албан бичгээр хариу хүргүүлсэн байна.

№18  2026.05.21
Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл

 УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Б.Батбаатар: Засгийн газар энэ хуулийг батлуулаагүй нөхцөлд үүнээс үүдэх нэмэлт өртөг, ханшийн эрсдэл, зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлтийг төгрөгөөр тооцсон уу?

Энэ хууль улсын төсвийн сахилга батыг сулруулах уу эсхүл төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх үү,

Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орохгүй жил бүр хойшилбол гадагшаа алдах валютын урсгал, бодит өртийг төлбөрийн тэнцэл бүр дээр тооцсон уу?

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц баруун бүсийн эдийн засаг, улс төрийн тэнцвэрийн асуудлыг илэрхийлэх учир үүн дээр бүсийн хөгжлийн тэнцвэр, боломжоо яаж хангах тал дээр анхаарсан зүйл бий юу?

Ил тод байдлын талаар?

УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ А.Ариунзаяа: Зарчмын зөрүүтэй 206 санал ЭЗБХ-оос орж ирсэн. Жил болгон ингэж оруулж ирдэг хэдий ч төлөвлөгөөнүүд болон хууль тогтоомжтой уялдаж байна уу? Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх тухай асуудал юу болж байна вэ?
УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ С.Бямбацогт: Зарчмын зөрүүтэй саналууд нь хууль зөрчсөн эсэхийг судалсан уу? Хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдаж байна уу? УИХТГ мэргэжил, арга зүйн туслалцаа болон ЭЗБХ ямар шийдэл байх талаар гаргалаа гарган, гүйцээн боловсруулах, олон саналуудыг цэгцлэх. Хуулийн хугацаанд багтаах үүрэг өглөө.
ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН • УИХТГ болон ЭЗБХ ЭЗБХ-ноос Байнгын хороо эцсийн хэлэлцүүлгийг хийх үед эдгээр саналуудыг дахин хэлэлцээд дэмжээгүй.
УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ Д.Ганмаа: Эрэгтэй, эмэгтэйчүүдийн дундаж наслалт багасаж, эрсдэлтэй хүчин зүйл байгаа талаар оруулж ирсэн байна. Суурь түвшин нь ямар байгаа талаар болон ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ямар болгох талаар мэдээлэл өгнө үү. Тоо, баримттай хариулж өгнө үү. Уламжлалт анагаах ухааны асуудлыг эрт илрүүлэг хэлбэрээр шийднэ гэж байгаа нь хэр нийцтэй вэ? Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах шийдэх гэдэг дээр эмнэлэг барина гэсэн байгаа дээр хариулт авмаар байна. Цогц хариулт авмаар байна.
УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ • УИХ-ын гишүүн Д.Ганмаагийн асуусан асуултад тодорхой бичгээр хүргүүлэх.
ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН • Эрүүл мэндийн яам 2026.06.25-ны Эрүүл мэндийн яамны 01/3117 дугаартай албан бичгээр хариу хүргүүлсэн.

№21 2026.05.22 Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг
УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ Г.Уянгахишиг: Хүн амын орлогын албан татварын тухай хуульд индексжүүлсэн, шатлалтай хөнгөлөлт байсан. Одоо бол шатлалгүй болгон өөрчилж оруулж ирж байна. Зорилгыг нь бол ойлгож байна. Залуу насны бүлгийг дэмжих чиглэлээр тооцоолол судалгаа гаргуулах хүсэлтэй. Мөн зарчмын зөрүүтэй санал гаргах хүсэлтэй байна. 2.5 сая төгрөг хүртэлх цалинтай иргэдэд татварыг 5 хувь хүртэлх байхаар тооцоолол гаргаж, төсөвт ямар нөлөө үзүүлэх талаар харьцуулсан мэдээлэл, судалгаа гаргаж

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: О. Саранчулуун гишүүнд бичгээр хариу өгье

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

• Гадаад хэргийн яам

Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгээс 2026.06.02-ны өдрийн 01/2772 тоот албан бичгээр Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуунд асуултын хариуг хүргүүлсэн байна

 2026.05.28

№24

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл

 УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Б. Түвшин: Энэ 127 гэдэг тэнцвэржүүлсэн нүүрсний үнэ, өнөөдрийн зах зээл дээр байгаа 68 доллар гэдэг хоёрын бодит орлого, тооцооллын орлого хоёрын сан нь байгаа юу, дахин төсвийн тодотгол хийхгүй биз дээ гэдэгт тодорхой хариулт авмаар байна.

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: Б. Түвшин гишүүний асуултуудад нэмээд бичгээр хариулт өгөөрэй.

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

• Эдийн засаг, хөгжлийн яам

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшинд тухайн асуудлыг хэлэлцэж байх үед хариултыг өгсөн.

 2026.05.28

№25

"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл

 УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Ц. Туваан: Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгон буюу 3-р баг дээр 420 сая төгрөгөөр баригдаад, дуусаагүй халуун усны газар байна. Энэ асуудал дээр хариулт өгөөч.

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: Сэлэнгэ аймгийн Шаамар сумын асуудалд бичгээр хариулт өгөөрэй.

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: Л. Мөнхбаясгалан гишүүнд бичгээр хариу өгье

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

- Эрүүл мэндийн яам

Эрүүл мэндийн сайд Э.Батшугараас 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/2617 тоот албан бичгээр Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгаланд асуултын хариуг хүргүүлсэн байна.

№28

 2026.05.28

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 25 дахь илтгэл

 УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Б. Хэрлэн: Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх нь хангагдаж байгаа эсэхийг ямар хэмжүүрээр үнэлж дүгнэдэг юм бэ?

Дээрх эрхийг насны бүлгээр нь авч үзвэл хэн уг эрхээ хангуулж чадахгүй байна вэ, эмнэлгийн аль шатанд энэ эрх нь зөрчигдөөд байна, ямар өвчнөөр өвчсөн тохиолдолд энэ эрх нь зөрчигдөөд байгааг тодорхой мэдээлэл өгнө үү?

Өнөөгийн тогтолцоо хүүхдийн ямар эрхийг нь хамгаалах боломжийг нь бүрдүүлээд ямар эрхийг нь хамгаалж чадахгүй байна вэ? Эрчүүдийн эрүүл мэндэд тулгамдаж буй хүчин зүйлүүдийн учир шалтгааны гүн рүү нь орж судалсан талаар тодорхой мэдээлэл өгнө үү?

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: Б.Хэрлэн гишүүний асуултуудад бичгээр тодорхой шийдэл танилцуулаарай.

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

- Хүний эрхийн үндэсний комисс

Монгол улсын хүний эрхийн комисс 2026.06.05 № 01/1185 хариу албан бичиг ирсэн байна.

№29

 2026.05.29

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах туахй хуулийн төсөл /УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин нарын 40 гишүүн 2025.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэ/

 УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Ө.Шижир: Асуудал хэлэлцэж эхлэхийн өмнө УИХ-ын дарга Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24, 21.25 дахь хэсгүүдийг уншиж танилцуулдаг. Хэлэлцэж буй

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 03/3709 тоот албан бичгээр асуултын хариултыг хүргүүлсэн байна.	
№31	2026.06.05 Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /УИХ-ын гишүүн Э.Болормаа нарын 19 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн/
УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ С.Ганбаатар: Хуулийн төсөлд Засгийн газраас 26 зүйлээр 45 санал хүргүүлсэн. Тэдгээр саналуудаас хэд нь хуулинд төсөлд орсон ороогүй талаар, ороогүй бол яагаад гэдгийг тайлбарлана уу?	
УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ С.Бямбацогт: УИХ-ын гишүүн С.Ганбаатарын асуултад бичгээр хариу өгөх.	
ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН • Монголбанк 2026.06.19-ний өдөр А-16/524 дугаартай албан бичиг хүргүүлсэн.	

№32	2026.06.11 Бизнесийн эрх чөлөөний тухай хууль
УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ О. Саранчулуун: Хууль эрх зүйн, төрийн зохицуулалтын орчны индекс энэ хуулийн дараа хэрхэн сайжрах вэ? Энэ талын тооцоолол байгаа юу?	
УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ С.Бямбацогт: Дутуу хариултуудыг бичгээр гүйцээж өгөөрэй.	
ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН • ЭЗХЯ ЭЗХЯ-наас 2026.07.02-ны өдрийн 01/2049 дугаартай хариу албан бичиг хүргүүлсэн.	
№33	2026.06.11 Бизнесийн эрх чөлөөний тухай хууль

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: О.Саранчулуун гишүүний асуултад бичгээр хариулт өгье.

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

• Татварын ерөнхий газар 2026.06.16-ны өдрийн 01/1902 дугаар албан бичгээр хариу өгсөн байна.

 2026.06.18

№36

Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: Хэрэгжихгүй байгаа хуулиудыг яаж хэрэгжүүлэх талаар 2026 оны 06 дугаар сард багтаан шийдэл гарган танилцуулах.

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

• УИХ-ын Тамгын газар

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газар үнэлгээ хийгдээгүй хуулийн жагсаалт гаргах үйл ажиллагаа явагдаж байгаа тул үнэлгээ хийх шаардлагатай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийнэ.

 2026.06.19

№37

Ойн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд/

 УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Б.Хэрлэн: Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан 4 чиглэлийн 7 асуулт асуусан боловч 2-т нь л хариулт авлаа. Дутуу авсан хариултуудыг бичгээр хүргүүлж, хариултаа бичгээр авах хүсэлтэй байна.

 УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: Б.Хэрлэн гишүүний асуултуудад бичгээр хариулт өгье.

 ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

• БОУАӨЯ

БОУАӨЯ-ны 2026.06.26-ны 01/3954 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон "Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл / Засгийн газар 2026.06.17 - ны өдөр өргөн мэдүүлсэн

☞ УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Д.Энхтүвшин: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хариуцлага тооцох заалт нь хуульд байхгүй заалтыг ишэлсэн байна. Хууль хоорондын нийцлийн асуудал гарч байна.

🗳️ УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: Гишүүдийн асуусан асуултад хугацаандаа тааруулж хариу өгж амжихгүй эсхүл дутуу хариулбал бичгээр хариулт өгөхөөр үүрэг авдаг хэдий ч УИХ-ын гишүүдэд бичгээр хариу өгдөггүй, эсхүл хангалтгүй хариулт өгч байна. Иймд УИХ-ын Тамгын газар чуулган завсарлагааны хугацаанд хэрхэн үүрэгжүүлэх, чанаржуулах талаар хуулийн төсөл боловсруулъя.

III ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

Улсын Их Хурлын Тамгын газар

Тамгын газрын Тэргүүн дэд даргад асуудлыг танилцуулан, хуулийн төсөл боловсруулахаар холбогдох албан хаагчид чиглэл өгсөн.

📅 2026.06.19

№41

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон "Монгол Улсын 2025 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл / Засгийн газар 2026.06.17 - ны өдөр өргөн мэдүүлсэн

☞ УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

О.Батнайрамдал: Монголын татварын алба Оюу Толгой ХХК 1.6 их наяд төгрөгийн татварын акт тавьсны дагуу төлбөр орж ирсэн. Тэр мөнгийг ямар бүртгэлээр бүртгэж авсан бэ?

🗳️ УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: УИХ-ын гишүүн О.Батнайрамдалын асуултад бичгээр бүрэн гүйцэт хариулт өгье.

III ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

Монгол Улсын Сангийн сайд З.Мэндсайхан 2026.06.24-ний өдрийн 01/7783 дугаартай албан бичгээр хариу өгсөн болно.

📅 2026.06.25

№42

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх

☞ УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

М.Бадамсүрэн: Татвар, нийгмийн даатгалын актыг хэдэн төгрөг, хэдэн жилийн турш тавигдсан бэ? Засгийн газарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр ноогдол ашиг жилд хэдэн төгрөг улсын төсөвт хувиарлагдаж байгаа вэ? Үүнээс нөлөөлөлд өртөж байгаа Дорнод аймагт хэдэн төгрөг хувиарлагдаж байгаа вэ, сүүлийн таван жилийн байдлаарх мэдээллийг асуумаар байна.

🗳️ УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

С.Бямбацогт: Сангийн яамныхан актуудтай холбоотой орж байгаа орлого, өгөөжтэй холбоотой асуудлуудаар тодорхой мэдээлэл бэлтгэж өгөөрэй.

III ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

•Үндэсний аудитын газар.

Үндэсний аудитын газрын зүгээс холбогдох эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж байгаа бөгөөд Засгийн газарт хариуцлага тооцох хууль санаачлах бүрэн эрхгүй тул өгөгдсөн үүргийг бие даан хэрэгжүүлэх боломжгүй. Харин Төрийн аудитын байгууллагаас олон жил дараалан тотоосон акт, албан шаардлага, алдаа зөрчил нь давтагдах шинжтэй, хэрэгжилт хангалтгүй байгаа шийдвэрийг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурлыг мэдээлэлээр хангаж тогтоолын төсөл санаачлан боловсруулсан тохиолдолд шаардлагатай саналыг гаргаж хамтран ажиллах боломжтой гэсэн тайлбар ирүүлсэн.

IV УИХ-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ / ҮГ

Б.Бейсен: Шинээр орон сууцны барилгыг хүлээн авдаг улсын комисс нь яагаад ийм шаардлага хангахгүй жишээлбэл Эко констракшны барилга айл өрх байрандаа ороход зэвтэй ус гардаг, гаднаа машины зогсоол байхгүй байхад яагаад улсын комисс хүлээн аваад байгаа вэ? Энэ тал дээр хяналт шалгалт хийж болох уу?

V УИХ-ЫН ДАРГЫН ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ

Б.Пүрэвдорж: Бичгээр хариу өгье.

III ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ АВСАН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАН

•НЗДТГ

НЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг Хяналт шалгалтын газарт НОСБГ-аас 2026.07.02-ны өдрийн 01/1233 дугаартай албан бичгээр Б.Бейсен гишүүний асуудлаар хяналт шалгалт хийх талаар хүсэлт хүргүүлсэн байна.

Боловсруулсан

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
АЖЛЫН АЛБАНЫ РЕФЕРЕНТ

Батцэцэг

Б.БАТЦЭЦЭГ

--- оОо ---